

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-23

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 6-23

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, дэгийн байнгын хорооны 12 дугаар сарын 09-ний өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 12 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: *Б.Баярбаатар*.

Нэг. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, мөн зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Хэрлэн, А.Ариунзаяа нарын тавьсан асуултад Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, А.Ариунзаяа нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зэрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Рэгдэл: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.	

Байнгын хорооноос гараж санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Үг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусае

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууним, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, мөн зөвлөлийн Ажлын албаны дарга В.Жавзан, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг зүйл, заалт бүрээр хэлэлцэв.

1.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Хуулийн төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

3.“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Рэгдэл: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	6
Бүгд:	11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.	

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн saatlyin улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргасныг Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл уламжлав.

Д.Рэгдэл: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.	

Д.Рэгдэл: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 11 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Д.Рэгдэл: “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяагийн “дэмжсэн” санал техникийн saatlyн улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 11 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг зүйл, заалт бүрээр хэлэлцэж дуусав.

Үг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 07 минут үргэлжилж, 12 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 91.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 26 минут.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Рэгдэл: Байнгын хорооны хурлын ирц бүрдсэн тул хурал эхлэхэд бэлэн боллоо.

Гишүүдийнхээ ирцийг танилцуулъя. Баярмагнай Баярбаатар чөлөөтэй байгаа. Аюушийн Ариунзаяа ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн ирсэн байна. Жамбын Батсуурь гишүүн ирсэн байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна. Болдын Жавхлан гишүүн одоо ороод ирнэ. Жаргалсайхан гишүүн ирээгүй байна. Лодойсамбуу гишүүн ирсэн байна. Очирбат гишүүн ирсэн байна. Рэгдэл ирсэн. Хэрлэн гишүүн ирсэн байна. Ингээд гишүүдийн ирц 66.7 хувьтай байгаа тул хурлынхаа ирцийг ингээд танилцуулж дууслаа. Хурал эхлэхэд бэлэн боллоо.

Байнгын хороогоор хэлэлцэх асуудлаа танилцуулж байх уу? Тэгье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэх юм байна.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудлын талаар манай Байнгын хорооны гишүүдэд асуулт, саналтай гишүүд байна уу?

Хэлэлцэх асуудал танилцуулж дууслаа.

Одоо бид нар хэлэлцүүлэг, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслүүдийн хоёрдугаар хэлэлцүүлгийг эхэль耶.

Хэлэлцүүлэг эхлэхийн өмнө ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсгийн Жавхлан сайд одоо орж ирнэ гэсэн. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан ирсэн байна. Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбууным ирсэн байна. Гүйцэтгэл -Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд ирсэн байна Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны дарга Жавзан ирсэн байна. Ёс зүйн хорооны ажлын албаны дарга Ганбаатар ирсэн байна. Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж ирсэн байна. Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх ирсэн байна. Ингээд ажлын хэсэг танилцуулж дууслаа.

Одоо хэлэлцүүлэг үргэлжлүүлэхийн тулд Жавхлан сайдыг түр хүлээе даа. Төрөө танилцуулъя гээд байна.

Би Их Хурлын дэгийн тухай хуулийн 2 заалтыг танилцуулъя. 1 дэх заалт нь Төсвийн болон бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд нам, эвслийн бүлэг төсвийн төслийг хэлэлцэнэ гээд 71.1-д заасан байна.

71.2-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын болон Дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцууллаа гээд хуульд заачихсан юм байна. Тэгэхээр бид нар Жавхлан сайдыг хүлээх ёстой юм байна.

Жавхлан сайд орж ирлээ. Жавхлан сайд манай Байнгын хорооны гишүүн учраас ирцээ бүртгүүлээд яагаарай. Эхлээд ажлын хэсгийн бүрэлдэхүүн танилцуулчихсан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх тани танилцуулгыг манай Байнгын хорооны гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан хийнэ. Жавхлан сайдын микрофон.

Б.Жавхлан: Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтвортгуй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 онд төсвийн үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр төсөвт бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурал нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээж авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн тэнцлийг боловсруулж өргөн барьж танилцуулж байна.

Төсвийн төсөлд зардлыг бууруулахад дараах зарчим баримталлаа.

1. Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гараад 1 удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтворт суурьшилтай ажилласан тэтгэвэр, тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр. Мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн шүүхийн байгууллагууд болон Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагуудын урсгал зардлыг хэвээр нь танилцуулж байна.

2. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-100 хувь бууруулна.

Нэгд нь салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь орууллаа.

Б. Соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино үйлдвэрлэл,? кино урлагийг дэмжих сан, засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын төлөвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулна.

В. Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр, шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин, төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал. Эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатын төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруульяа.

Г. Улсын төсвийн хөрөнгөөр шинээр гүйцэтгэх геологи хайгуул судалгааны ажлыг 50 хувь бууруулна.

Дээр дурдсан 5-100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, норматив эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг цаашид яаралтай дуусгаяа.

4. Гэрээ байгуулаагүй, ажил эрхлээгүй улсын төсөв, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулна.

5. Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж хэлэлцээрийн шатад байгаа төслүүдийг хойшлуулъя.

6. Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлуулъя.

7. Хавдар судлалын үндэсний төв 2 хөрөнгө оруулалтыг нэмж тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394.8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувь нийт зардал байгаа. Зээлийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувь хүрч, нэгдсэн төсвийн тэнцэл, тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж байна.

Суурь тэнцэл ДНБ-ий 3.3 их хувийн нэмэх, эерэг байхаар байхаар байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 25 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Рэгдэл: Жавхлан сайдад баярлалаа.

Одоо нэгдүгээр асуудлынхаа хүрээнд 2 дахь танилцуулга хийгдэнэ. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбууням танилцуулна. 6 дугаар микрофон.

Я.Самбууням: Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтвортгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан нь ач холбогдолтой болсон байна.

Иймд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн хүлээн авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулсанд дүгнэлт өглөө.

Тухайн аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашигийг дээшлүүлэх зорилтод нийцсэн эсэхийг хянахад чиглэсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага ба цэвэр зээлийн дунг 33 их наяд 470 тэрбум буюу ДНБ-ий 35.2 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 3 их наяд 173.4 тэрбум төгрөгийн ашигтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 3,3 хувийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байхаар тус тус төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ. Үүнд:

Улсын Их Хурлын даргын 2025 онд төвлөрүүлэх орлогыг 0.1 тэрбум, зардлыг 172.4 тэрбум буюу суурь зардлаас 18.6 тэрбум төгрөгөөр бууруулж, Төрийн албаны зөвлөлийн даргын төвлөрүүлэх орлогыг 0.2 тэрбум, зардлыг 20.7 буюу суурь түвшнээс 1.2 тэрбум төгрөгөөр бууруулж, Авиалагтай тэмцэх газрын төсвийг 56.9 тэрбум буюу суурь түвшнээс 1.3 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж баталсан, төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, үзэл баримтлал, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй байна.

Нэгдүгээрт, Гадаад хүчин зүйлийн нөлөөлөл, уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-27 оны төсвийн төсөөллийг тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

3. Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өргтгийг үндэслэлтэйд тооцож, үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4. Төсвийн ургал зарлагыг хумъж зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын ДНБ-д эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 оны төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

5. Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна.

6. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэж тусгасан нь Улсын Их Хурлын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжтой нийцэхгүй байна гэж дүгнэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Рэгдэл: Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбуунаям танд их баярлалаа.

Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 25 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс гишүүдэд хүргүүлсэн байгаа.

Ийм учраас одоо хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн Ерөнхийлөгч захирагчдаас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байвал нэрээ өгнө үү манай байнгын хорооноос. Асуулт.

Тэгье ингээд Байнгын хорооны З гишүүн асуулт асуух юм байна. Баасанжаргал гишүүн, Хэрлэн гишүүн, Ариунзаяа гишүүн. Асуулт алхам цохих билүү? Ингээд З гишүүнээр тасалъя.

Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Х.Баасанжаргал: Нэг зүйлийг тодруулаадахъя. Энэ төсөв буурч, хасагдаж байгаатай холбоотой ялангуяа нөгөө зөвлөл, хороо, комиссын гишүүнд ажлын хөлс, урамшуулал олгох зардлыг 100 хувь гэж хасаж байгаатай холбоотой Төрийн албаны төв зөвлөлийн гишүүд давхар ёс зүйн хорооныхоо гишүүний ажлыг хийж, давхар ажил албан тушаал хавсарч байгаатай холбоотой нэмэлт тодорхой хэмжээний урамшуулал авдаг гэж би ойлгодог.

Түүнээс гадна орон тооны бус 4 гишүүн байгаа. Тэгэхээр эдгээрийн цалин хөлс, урамшуулал бүгд хасагдаж орж ирж байна гэсэн үг үү? Тэгэхээр Ёс зүйн хорооны гишүүдийн цалин хөлсний асуудал хэрхэн шийдэгдэж байгаа болоо гэдэг нэг асуулт.

Д.Рэгдэл: Сангийн яамны газрын дарга Санжаадорж хариулах юм байна.
Микрофон 9.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариульяа.

Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээр бол Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин, хөлснөөс гадуур ажил, цалин хөлс, урамшуулал олгохыг хориглоно гэж орж ирсэн байгаа.

Энэ дээр бол тухайлсан Төрийн албаны зөвлөл бол хамрагдахгүй. Яагаад гэхлээр хуулиар бол цалин, хөлс авах тэр эрх нь байж байгаа. Зүгээр энийг оруулсан агуулга нь юу байсан бэ гэхлээр юу гэдэг юм яамны газрын дарга ч байдаг юм уу, ажлын хэсэг юм уу комисст орж ажиллачихад давхар урамшуулал авч байгаа энэ асуудлыг бол зогсоох, мөн хуульгүй комисс, ажлын хэсэг байгуулгасан бол эдгээр юнууд бол дандаа цалин, хөлсгүйгээр байхаар тэгж бодож, тооцож оруулж ирсэн байх. Тийм, давхар авахгүйгээр үндсэн цалингаа аваад явна. Тухайн төрийн албан хаагч бол тухайн байгууллагаасаа цалингаа аваад явна. Тэгээд чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлж байгаа ажил гэж үзэж байгаа учраас давхар цалин авахгүй л гэдэг санал.

Д.Рэгдэл: Одоо Баатарсайхан гишүүн бас нэмэлт хариулт өгөх байх. Тэрний дараа тодруулах зүйл байвал тодруулчих. 3 дугаар микрофон.

Д.Баатарсайхан: Сая Сангийн яамнаас хариулж байна. Төсөвтөө багтаагаад Төрийн албаны зөвлөлийнхөө гишүүний цалин, тэр дээр нь Ёс зүйн хорооны гишүүний урамшуулал авдаг байгаа. Цалин бол авдаггүй. Тэгэхээр одоо бол энэ орж ирсэн төсвийн төсөл, энэ хүрээндээ ингээд яваад байх бололцоотой гэж харж байгаа.

Д.Рэгдэл: Баасанжаргал гишүүнд нэмэлт асуулт байна уу? Тодруулга 1 минут

Х.Баасанжаргал: Яах вэ би тэр Төрийн албаны зөвлөлийн яг орон тооны гишүүд бол яах вэ. Орон тооны бус 4 гишүүн Ёс зүйн хорооны гишүүний ажлыг хийж байгаа шүү дээ. Тэр хүмүүсийн урамшуулал хасагдаад байна уу хасагдахгүй одоогийнхоо байгаагаараа явж байгаа юм уу л гэж асууж байгаа гэсэн үг. Энэ дээр 100 хувь хасагдаж гэж орж ирээд байгаа учраас тодруулаад байгаа гэсэн үг. Тэр үндсэн чиг үүрэгтэй хамааралгүй шүү дээ тэр хүмүүс чинь орон тооны бус 4 гишүүн.

Д.Рэгдэл: Асуулт тавигдлаа. Төрийн албаны зөвлөлөөс хариулах уу? 3 дугаар микрофон Төрийн албаны зөвлөлийн гишүүн Баатарсайхан.

Д.Баатарсайхан: Орон тооны бус 4 гишүүний урамшуулал бол хасагдахгүй байгаа. Хасагдахгүйгээр явж байгаа.

Д.Рэгдэл: Одоо Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн асуулт тавина.

Б.Хэрлэн: Бүгдэд нь энэ өглөөний мэнд хүргэе.

Тэгэхээр би Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлтэй холбоотой асуулт асууя гэж бодож байна. Тэгэхээр Төрийн албаны зөвлөлийн гол үндсэн чиг үүрэг нь болоод ирэхээр маргааныг шийдвэрлэх тухай асуудал байдаг. Ялангуяа төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, ер нь сонгон шалгаруулах, албан тушаалд томилох, дэвшүүлэх, ажил үүргээс нь чөлөөлөх, халахтай холбоотой ийм хөдөлмөрийн харилцаан дээр гарсан маргаануудыг шийдвэрлэх гэдэг Төрийн албаны зөвлөлийн гол үндсэн чиг үүрэг байдаг.

Тэгэхээр энэ 25 оны Төрийн албаны зөвлөлийн төсөв дотор хараад энэ чиг үүрэг яг ямар хөтөлбөр гэсэн нэр, ямар хөтөлбөрийн нэрээр орж ирж байгаа вэ? Энэ дээр ер нь хэдэн төгрөг төсөвлөгдж байгаа вэ? Энийг би асуумаар байна.

Д.Рэгдэл: Төрийн албаны зөвлөлийн гишүүн Баатарсайхан хариулна.
Микрофон 3.

Д.Баатарсайхан: Хэрлэн гишүүний асуултад хариульяа.

Төрийн албан хаагчийн эрх нь зөрчигдсөн асуудалтай холбоотой шүүхийн өмнөх байдлаар Төрийн албаны зөвлөл бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн албан хаагчдын маргаан, гомдлыг хянан шийдвэрлэдэг байгаа. Манай гол акцент өгч байгаа зүйл маань төрд учирсан хохирлыг бас нөхөн төлүүлэх үйл ажиллагаа дээр нэлээн анхаарлаа тавьж байгаа. Энд төрийн албан хаагчийг хууль бусаар халсан, чөлөөлсөн албан тушаал бууруулсан. Дээрээс нь шаардлага хангахгүй хүнийг төрийн албананд албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангагүй хүнийг, шалгалт өгөөгүй хүнийг томилсон байвал бас энэ хэмжээний төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр ажиллаж байгаа.

Д.Рэгдэл: Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн нэмэлт асуулт.

Б.Хэрлэн: Тэгэхээр 13.1.4 гэсэн энэ хөтөлбөр тусгагдсан тэгээд төрийн албан хаагч Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгуулна гэсэн энэ хөтөлбөрийн доор энэ ажлыг төлөвлөж байна гэж ойлгох уу?

Д.Рэгдэл: Баатарсайхан гишүүн 3 дугаар микрофон.

Д.Баатарсайхан: Яг л саяын хэлснээрээ төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр энэ үйл ажиллагааг зохион байгуулж байгаа. Тэгээд энэ зохион байгуулж байгаа үйл ажиллагаа маань бас цахимд шилжиж, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны гол цөм мэдээлэл цуглувладаг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоонд төрд учирсан хохирлыг төлөвлөсөн байдал, түүнд тавьж байгаа шаардлагууд, Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа ажил энэ чигтээ бас тусаж байгаа.

Д.Рэгдэл: Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа асуултад тавина.

А.Ариунзаяа: Сайн байцгаанаа уу? 2, 3 чиглэлээр зарим зүйлсийг тодруулъяа.

Засгийн газраас салбар харгалзахгүй бүх төсөвт зарим зардлуудыг 100 хувь хасжээ. Үүн дотор барилгын тухайн байгууллагын тавилга, эд хогшил болон биеийн тамирын уралдаан, тэмцээн зохион байгуулахгүй байх. Энийг бол ойлгож байна. Гагцхүү Төрийн албаны зөвлөл чиг үүрэг нь үндсэн чиг үүрэгт нь энэ сургалт, семинар зохион байгуулах ажил ордоггүй юм уу? Энэ зардал нь 100 хувь хасагдчихлаар та нар чинь төрийн албан хаагчдаа хэрхэн яаж сургах гээд байна вэ? Төрийн албаны дэргэд байгуулагдсан Ёс зүйн хороо маань үндсэн чиг үүрэг нь энэ сургалт баймаар юм. Тэгээд энэ зардал нь орохгүй гэхлээр ер нь үйл ажиллагаа явуулж чадах нь уу, чадахгүй нь уу? Ер нь эргээд нөгөө татан буугдах тал руугаа явах нь уу?

Хоёр дахь нь энэ дуудлагын автомашин хөлслөх зардлыг бас 100 хувь хасжээ. Өмнөх чиглэлүүдээрээ тухайн байгууллагын, энэ байгууллага дээр байсан машинуудыг бүгдийг нь заруулаад, тэгээд та нар хэрэгцээтэй үедээ дуудлагаар автомашин хөлсөлж бай гэдэг чиглэл өгчхөөд, одоо бүр дуудлагын автомашиныг ч хүртэл хөлслөх зардлыг нь өгөхгүй болохоор чинь энэ байгууллагууд чинь бас үйл ажиллагаа догдлохгүй юу? Яагаад энэ зардлыг бас хасах болчхов? Гэрээт ажилтан ажиллуулахыг бас хасчижжээ. Үндсэн орон тоогоо бүрэн гүйцэд авч чадаагүй, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж чадахгүй байгаа үед гэрээт ажилтныг ажиллуулдаг. Миний мэдэх Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр жишээлбэл, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын ажилтныг бол гэрээтээр ажиллуулдаг нь үндсэн орон тоонд ердөөсөө оруулж өгдөггүй.

Гэхдээ ингээд энэ үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай орон тоонууд байдгийг хасаад байгаа нь ямар учиртай юм бэ? Төрийн албаны зөвлөл энэ төсвийн дагуу ямар чиг үүргүүд нь тасалдах эрсдэл үүсэж байна вэ? Эс үгүй бол бүх юм зөв сайхан гээд явах уу?

Хоёр дахь асуудал нь энэ түрүүчийн чуулганаар Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж сонгуулиас хойш 6000 төрийн албан хаагч нэмэгдсэн гэж мэдэгдсэн. Энэ үнэхээрийн 6000 төрийн албан хаагч нэмэгдчихэв үү? Тэгээд яг сонгуулийн ар буюу 6 сараас хойш яг хэчнээн төрийн албан хаагч шинээр нэмэгдсэн юм? Нөгөө талдаа сонгуулиас хойш төрийн албан хаагчийн шилжилт хөдөлгөөн нэн ялангуяа яамдууд, яг харьяа агентлагууд дээр хэрхэн, ямар дүр төрхтэй байгаа вэ гэдэг дээр мэдээлэл өгч болох уу?

Д.Рэгдэл: 4 асуулт асуулаа. Ажлын хэсгээс хариулах 9 номерын микрофон Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариульяа.

Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр бол сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг бол аль болох цахимаар зохион байгуулах, ингэж цахимаар зохион байгуулахын зэрэгцээгээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх талаар бол тийм заалт орж ирсэн байгаа.

Яг Төрийн албаны зөвлөлийн байгууллагын хувьд яг төрийн албаны төв байгууллагын хувьд бол сургалтын зардал бол байхгүй. Сургалттай холбоотой зардлыг төрийн албан хаагчдын сургалтыг бол Удирдлагын академи зохион

байгуулж явж байгаа. Удирдлагын академийн зардлыг бол 10 хувиар бууруулаад бол орж ирсэн байгаа.

Шатахууны зардлыг бол шатахуун бол зайлшгүй шаардлагатай салбарууд болох эрүүл мэнд, онцгой байдал, хил гэх мэт төрийн тусгай байгууллагууд үндсэн чиг үүрэгтэй нь шатахуун заавал холбоотой эдгээр байгууллагууд дээр хэмнэлт хийгээгүй, бууруулаагүй. Бусад салбарууд дээр бол нэг зарчмаар бууруулаад явсан байгаа.

Д.Рэгдэл: Дахиад 2 асуултад хариулсангүй. Гэрээт ажилтны тухай нэг асуулт байсан санагдаж байна. Тэгээд төрийн албаны орон тооны тухай, төрийн албан хаагчдын орон тооны тухай асуулт. Ажлын хэсгээс хариулт Төрийн албаны зөвлөлийн гишүүн Баатарсайхан З дугаар микрофон.

Д.Баатарсайхан: Төрийн албаны зөвлөлийн гишүүн Баатарсайхан байна. Амарзаяа гишүүний асуултад хариульяа.

Төрийн албан хаагчийн тоо сонгуулиас хойш тэгж өсөөгүй. Яагаад вэ гэхээр зэрэг төрийн байгууллагууд нэмэгдээгүй байгаа. Нэмэгдээгүй учраас . Ерэнхийдөө улсын хэмжээнд үндсэн статистикаараа 226496 төрийн албан хаагч ажилласан. 9 сарын байдлаар би зүгээр дундын мэдээлэл ингээд хархаар зэрэг 20 орчим мянган төрийн албан хаагч ямар нэгэн байдлаар хөдөлгөөнд ороод чөлөөлөгдсөн гэдэг юм уу байгаа. Зөрөөд 18000 орчим төрийн албан хаагч мөн ажилд томилогдсон. Яг ингээд үзэхээр 2000 орчим төрийн албан хаагчаар төрийн албан хаагчийн тоо нэмэгдсэн. Энд нь яаж байгаа вэ гэхээр нийгмийн суурь үйлчилгээ үзүүлж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагууд нэмэгдсэнтэй холбоотойгоор тоо нэмэгд

Д.Рэгдэл: Бас нэг асуулт үлдчихлээ. Энэ гэрээт ажилтны талаар байр суурь байгаа шүү дээ. Ямархуу? 9 номерын микрофон Санжаадорж хариулах гэж байна тээ.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариульяа.

Гэрээт ажилчдын цалинг бол нольлолсон байгаа. Гэрээт ажилчдыг бол төрийн захиргааны болон төрийн тусгай байгууллагууд дээр бол бид аль болох төрийн албаны шалгалтаа өгсөн, нөөцөд бүртгэгдсэн, ингээд сэлгэх боломж байгаа, шинээр бас ажилд орох боломж байгаа. Энэ хууль журмынх нь дагуу орж ирэхийг л бид нар бол шаардаж байгаа. Энэ дагуу явж байгаа.

Харин төрийн үйлчилгээний албаны хувьд бол жаахан онцлогтой зүйл байгаа. Жишээ нь, боловсрол, эрүүл мэндийн хувьд бол, салбарын хувьд бол хөдөө орон нутагт, ялангуяа алслагдсан сумуудад тэтгэвэрт гарсан багш, эмч нарыг буцаагаад гэрээт байдлаар ажиллуулах шаардлага тулгарч байгаа. Энэ нь тухайн байгууллагадаа эрх нь бол байж байгаа.

Төрийн жинхэнэ алба бол өөрөө бол тангараг өргөж төрийн албан хаагч болдог энэ албан дээр гэрээт байдлаар тухайн хүний, тухайн чиг үүргийг орлож хүн ажиллах.../минут дуусав./

Д.Рэгдэл: Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Тэгэхээр Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж сонгуулиас хойш 600 төрийн албан хаагч нэмэгджээ гэж хэлдэг нь бол өөрөө их хариуцлагагүй, мэдээлэл дутуу мэдээлэл байсан байна гэдгийг бол ойлгож авлаа. Гэсэн хэдий ч сонгуулиас хойш яг энэ яамнууд дээр, агентлагууд дээр хүний нөөцийн сэлгэлт хэдий хэмжээнд хийгдсэн бэ гэдэг энэ асуултын хариултыг бол авч чадсангүй ээ. Тэгэхээр Төрийн албаны зөвлөл энэ тал дээрээ хариулж чадвал сайн байна.

Нөгөөдөх нь болохлоор энэ Ёс зүйн хорооны чиг үүрэгт нь энэ сургалтын ажил нэмэгдсэн шиг санаад байх юм. Энэ ёс зүйн хорооны бүтэц, орон тоо, чиг үүрэг яг хуульд зааснаараа үргэлжлэх боломжтой байна уу, үгүй юу гэдэг дээр хариулт өгнө үү.

Д.Рэгдэл: Төрийн албаны зөвлөлийн гишүүн Баатарсайхан хариулна.

Д.Баатарсайхан: Ёс зүйн хороон дээр сургалтын үйл ажиллагаа бас нэлээн зонхилно. Яагаад вэ гэхээр зэрэг сургалт, соён гэгээрүүлэх чиг үүрэг нэлээн явж байгаа. Тэгээд энэ ажлынхаа хүрээнд өнгөрсөн хаврын чуулганаар соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг батлуулсан байгаа. 2030 оныг хүртэл хэрэгжихээр энэ хөтөлбөр. Энэ хөтөлбөрийн хүрээнд бид сургалтыг зохион байгуулна, дээр нь ёс зүйн индексжүүлэх ажлыг хийнэ, ёс зүйн зөрчил гаргасан гомдол, гаргасан мэдээ, мэдээлэл энэ зүйлүүдийг цахимжуулах, нийтэд тэр даруй, нэн даруй мэдээлж байх ийм үйл ажиллагаанууд чухал байгаа. Тэгээд энэ хасагдаж байгаа байдлаар жоохон хүнд байх байх. Ямар ч байсан бид энэ сургалтыг тасалдуулахгүй, соён гэгээрүүлэх үйл ажиллагаагаа хийж явуулна л гэдэг тал дээр ажиллана.

Д.Рэгдэл: Ингээд гишүүд асуулт асууж, хариултаа авч дууслаа.

Ер нь төрийн албан хаагчдын тухай гэж хэлэхэд шинээр томилогдсон сайд нар бараг яамныхаа аппаратад төдийгүй салбартаа баг авч очиж байгаа. Тийм мэдээлэл их ирж байгаа. Тэгэхээр Төрийн албаны зөвлөл энэ дээр маш сайн хяналт тавьж ажилламаар байгаа юм. Тэнд Төрийн албаны тухай хуулийн зөрчил байна уу, үгүй юу, ёс зүйн асуудал байна уу, үгүй юу гэдгийг Монгол Улсын Ёс зүйн хороо бас анхаарч ажиллах ёстой гэж бид нар үзэж байгаа. Тэгээд энэ талаар та бүхэн бас дараа нь, төсөв батлагдсаны дараа мэдээлэл хийх байх гэж найдаж байна.

Ингээд асуулт, хариулт дууслаа.

Одоо санал хэлэх энэ хэлэлцэж байгаа асуудлаар санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэrsээ өгнө үү.

Санал хэлэх гишүүн байхгүй юм байна. Хэрлэн, санал хэлэх гишүүд өөр асуудал алга тээ. 1 гишүүн санал, 2. Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн, Ариунзаяа нар саналаа хэлэх юм байна.

Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн.

Б.Хэрлэн: Тэгэхээр түрүүн сая Ариунзаяа гишүүн, Рэгдэл гишүүн бас өөрсдийнхөө хэлсэн комментдоо ерөнхийдөө өнөөдөр төрийн албанад бас халаа, сэлгээ их байгаад байна. Хууль бус халаа сэлгээ их байгаад байна төрийн албан

хаагчдын. Ялангуяа төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрлөх эрх зөрчигдөөд байгаа тухай асуудлыг тодорхой бас баримттайгаар ингээд хөндөж байна. Тэгэхээр түрүүнийхээ асуулттай холбогдуулаад хэлэхэд ер нь маргааныг хянан шийдвэрлэх гэдэг Төрийн албаны зөвлөлийн нэг гол үндсэн чиг үүрэг яах аргагүй мөн. Тэгээд яг энэктэй холбоотой хөтөлбөр, дэд хөтөлбөрийг энэ төсөвтөө маш тодорхой зааж оруулж өгөх хэрэгтэй байна.

Одоо энд байгаа 13.1.4 гэдэг болоод өрөөсөө Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, дүгнэнэ гэж байгаа байхгүй юу. Тэгээд зөрчил байх юм бол арилгана гэсэн ийм байдлаар төлөвлөсөн байгаад байна л даа. Тэгэхээр энэ яг төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа зөрчигдэж байгаа тохиолдолд та нар яг юу хийх гэж байгаа юм бэ гэдэг тухай асуудлыг бүрэн тодорхой илэрхийлж чадахгүй байна.

Өөрөөр хэлэх юм бол, яг тэр хөтөлбөрөөр төсөвлөх арга зүй гэдэг юмныхаа дагуу энэ хөтөлбөр чинь яг юу хийх гэж байгаа юм, энэ хөтөлбөрийн хүрээнд яг ямар ямар ажлууд хийгдэх ёстой юм бэ гэдэг тухай тодорхой ойлголт, тодорхой чиглүүлэг өгч байх ёстой энэ баримт бичиг дээрээ та нар бас ер нь цаашдаа анхаарах хэрэгтэй юм байна гэж би хэлэх гэж байна.

Тэгэхээр ингэж байна л даа 13.1.4-ийн цаана ингээд нөгөө дэд хөтөлбөрт нь болоод ирэхээр нөгөө цахим системийг хөгжүүлнэ гээд явчхаад байгаа байхгүй юу. Энэ чинь хамаарахгүй шүү дээ энэ ажилд чинь. Маргаан шийдвэрлэх ажилд энэ бол хамаарахгүй.

Тэгэхээр 13.1.4-ийн хөтөлбөрийн нэршлийг өөрчлөх, өөрчилбөл яасан юм бэ? Тухайлах юм бол Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг шийдвэрлэх гэж хэрвээ ингэж энэ хөтөлбөрийн нэрийг өөрчлөх юм бол арай илүү та нарын хийх ажил жаахан тодорхой болох юм болов уу гэж би нэгдүгээрт бодож байна.

Хоёрдугаарт нь бас 2 дахь санал юу байна вэ гэхээр ер нь бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын тухай танай дээр бас нэм мэдээд орж ирж байгаа. 8.4 хувиар нэмэгдсэн байгаа. Тэгэхээр саяын төсвийн хэлэлцүүлгийн явцад гарсан хамгийн нэг том асуудал бол яг энэ зардлыг тодорхой болгох тухай асуудал маш их яригдаж байгаа. Тэгэхээр юунд хэдэн төгрөг зarah гээд байгаа юм бэ гэдэг нь их тодорхой баймаар байна гээд. Энийг цаашид анхаараач.

Гурав дахь гол санаа юу вэ гэхээр ер нь одоо төрийн үйлчилгээг бас цахимаар төрийн үйлчилгээг хүргэх, ялангуяа Төрийн албаны зөвлөлийн хувьд болоод ирэхээр танай хэд хэдэн үйлчилгээ нэлээн их цахимжиж байгаа тоон шилжилтүүд бас нэлээн хийгдэж, тоон системд шилжүүлэх энэ ажиллагаа таны хувьд нэлээн хийгдэж байгаа. Тэгээд төрийн албан хаагчийн хувийн хэрэг, төрийн албан хаагчийн, төрийн албананд орох гэж байгаа хүмүүсийн шалгалтыг цахимаар авдаг гэх жишээтэйгээр ийм технологийн дэвшлийг их нэвтрүүлж байгаа.

Энэ эргээд Төрийн албаны зөвлөлийн зардлыг яаж бууруулж байгаа юм бэ? Бид нар өнөөдөр зардал хэмнэх тухай яриад байгаа. Тэгэхээр энэ зардлыг илүү үр ашигтай болгох талаасаа, өмнөхөөсөө энэ төрийн албаны шалгалтыг хэдэн төгрөгөөр хэмнэж явуулдаг болж байна. Төрийн албан хаагчийн бүртгэлийг цахимжуулснаараа танай орон тоо, үйл ажиллагаанд бас ингээд зардал хэдэн

төгрөгөөр хэмнэгдэж байгаа юм бэ гэдэг дээр өрөнхийдөө цаашдаа бас анхаарч энэ дээрээ бодолцож төсвөө бас хийх тал дээр цаашдаа анхаарна уу гэж би хэлэх гээд байгаа юм.

Д.Рэгдэл: Хэрлэн гишүүнд баярлалаа. Ариунзаяа гишүүн үг хэлэхээс өмнө Байнгын хорооны гишүүдэд бас мэдээлэл хүргээдэхье. Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналтай гишүүд байвал зарчмын зөрүүтэй саналаа бэлдэж байгаарай. Одоо гишүүд үг хэлээд дуусахтайгаа зэрэг дараа нь зарчмын зөрүүтэй саналыг авч Байнгын хороон дээр санал хураалт явуулна.

Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Би Засгийн газрын тэр дотроо Сангийн яамны зовлонг бол сайдаар ажиллаж байсан хүний хувьд бол маш сайн ойлгодог байгаа. Цаг хугацаандаа шахагдаад бид нар маш олон шийдвэрүүдийг хайчинд орчихлоо гэж хүч түрэн алдаатай шийдвэрүүдийг бас нэлээдгүй гаргадаг. Тэгээд энэ удаа бас хавтгайруулаад бүх салбаруудыг адилхан салбар харгалзахгүйгээр энэ хэрэгцээтэй зардлуудыг хасаж байгаа нь бол өөрөө бас цаашдаа ер нь буруу юм шүү. Энэ удаа дахиад л нөгөө хайчиндаа орчихсон. Дахиад л бүгдийг нь хавтгайруулаад л хасчихлаа. Орон тооны цомхотголын талаар яриад эхэлчихсэн байна лээ, яриад эхэлчихсэн байгаа. Ерөнхийлөгчийн Тамгын газраас ч байдаг юм уу өгсөн чиглэл, хууль санаачлагчаас Гантөмөр сайд эртээр чуулган дээр бас энэ орон тооны цомхотголыг хийнэ гэдэг асуудлыг бол ярьж байна лээ. Энэ орон тооны цомхотголыг хийхдээ Төрийн албаны зөвлөл маш сайн оролцоотой байгаасай гэж хүсэж байна. Орон тоо нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай салбарууд угаасаа байдаг. Харин орон тоог нь цомхотгох боломжтой ч гэсэн салбарууд байдаг. Энийг үгүйсгэхгүй.

Тэгэхээр үүнийгээ яг тэр мэргэжлийн байгууллага нь мэргэжлийн түвшинд тооцоо, судалгаатай өөрсдөө гаргахгүй бол энэ автоматаар бүхнийг хавтгайруулдаг асуудал чинь төрийн албыг маш их хүчгүйдүүлж байгаа шүү. Энэ дээрээ анхаараасай. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг ер нь бол дэмждэг дэмждэг. Гагцхүү дахиад л 2 туйлтай шийдвэрүүд гараад байдаг. Жишээлбэл, тэр яамны сайд, яамны Төрийн нарийн бичиг, яамны газрын дарга аль нэг хороонд, зөвлөлд ороод илүү урамшуулал аваад байгаа бол тэр буруу. Гагцхүү жишээлбэл, хүүхэд хамгааллаа ярихад хөдөө сумд хамтарсан баг гэж байдаг. Тэр хамтарсан багийн хүмүүс угаасаа ачаалалтай ажилладаг. Тэгээд тэдгээр хүмүүсийг угаасаа хэцүү хүнд, ачаалалтай ажил дээрээсээ нэмээд хамтарсан багтаа анхаараад, хүүхэд хамгааллын асуудалдаа анхаараад яв гээд энэ урамшууллыг олгодог нь тухайн хүмүүс өөрсдөө цалингаасаа хүртэл зарим зардлуудыг гаргаж ажилладаг энэ ажлыг нь бас үнэгүйдүүлж байгаа нэг хэлбэр мөн шүү.

Ийм учраас уг нь бол ингээд салбар түвшнээ ялгаж энэ хязгаарлалтуудаа тавих байсан юм гэж бас дахиад энэ үгэндээ хэльье. Нийгмийн бодлогын байнгын хороо эхлэх гэж байна. Тэнд бас энэ яг хүүхэд хамгааллын талаар бас асуултуудаа асуух болно. Баярлалаа.

Д.Рэгдэл: Гишүүд үг хэлж дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байвал саналынхаа томьёоллыг өгөөрэй.

Эхний санал ирсэн байна танилцуулъя. Энэ санал бол Төрийн албаны зөвлөлийн дарга 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо, хэмжээний үзүүлэлтэд холбогдуулаад 13.1.4 дэх томьёоллын өөрчилж найруулсан санал байна. Хуучин энд орж ирсэн томьёолол бол 13.1.4 төрийн төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгуулна гэсэн ийм томьёололтой орж ирсэн байна. Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүн Хэрлэнгийн оруулж ирж байгаа санал бол Төрийн албаны тухай хууль таслал тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг хянан шийдвэрлэх гэж оруулъя гэсэн ийм санал ирж байна.

Хэрлэн гишүүн саналаа тайлбарлах уу? Ямар үндэслэлтэй ингэж өөрчилж байгаа талаар.

Б.Хэрлэн: Тэгэхээр ерөнхийдөө маргаан хянан шийдвэрлэх гэдэг нь Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар бүлэгт дурдагдсанаар төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, тэгээд албанаас нь чөлөөлөх, түр чөлөөлөх, ажлаас нь халахтай холбоотой гарсан маргаан гомдлыг шийдвэрлэх тухай энэ дээр ийм үүрэг бол төрийн албаны гол нэг үүрэг гэгдэж байгаа.

Тэгэхээр энэ дээр томьёолсноор болоод ирэхээр Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, дүгнэнэ гээд явчихсан байгаа. Ерөнхийдөө маш ерөнхий байдлаар томьёологдчихсон. Энэ нь жишээлэх юм бол Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт сайн байсан учраас улс орны эдийн засаг хөгжиж байна гэх юм уу, эсвэл төрийн албаны хуулийн хэрэгжилт сүл байгаа учраас улс орны эдийн засаг, нийгмийн байдалд ийм сөрөг нөлөө үзүүлж байна гэдэг талаас нь үнэлгээ дүгнэлт өгөх гэж байгаа юм шиг ийм байдлаар томьёологдчихсон эргээд Төрийн албаны зөвлөл болоод төрийн албан хаагчдын хувьд яг нөгөө үйл ажиллагаанд нь чиглүүлэх, тодорхой зорилго, чиглэлийг нь оновчтой болгох гэсэн энэ утга санаа нь энд алдагдчихаад байна гэж үзээд байгаа юм.

Тийм учраас зайлшгүй танай нэг үндсэн чиг үүрэг болох 22 дугаар бүлэгтэй чинь холбоотойгоор маргааныг хянан шийдвэрлэх, хяналт тавьж маргааныг хянан шийдвэрлэх гэсэн энэ утга санааг агуулж, илүү тодорхой илэрхийлж томьёолбол энэ хөтөлбөр илүү ойлгомжтой болох юм болов уу гэж бодож байна.

Хөтөлбөрийн чинь дэд хөтөлбөр дотор байгаа 2 зүйл болоод ирэхээр бас сонин авцалдаагүй зүйл болчихсон байгаа. Тэрийгээ та бүхэн харин хараарай. Тухайлах юм бол цахим системийг хөгжүүлнэ энэ тэр гээд явчихсан байгаад байгаа. Тэгэхээр дэд хөтөлбөр, хөтөлбөр энэ тэр чинь авцалдаагүй болчлоод байгаа. Дээр нь таны үндсэн чиг үүрэгтэй, танай хуультай чинь бас их сайн холбогдохгүй байгаад байна шүү гэдгийг та бүхэн хараарай ер нь цаашдаа.

Д.Рэгдэл: Хэрлэн гишүүнд баярлалаа.

Одоо Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарсан маргааныг хянан шийдвэрлэх, хянан шийдвэрлэнэ гэж бичье. Бусадтай, хянан шийдвэрлэнэ гэсэн томьёоллоор зарчмын зөрүүтэй саналын хураалт, саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт гишүүд.

66.3 хувийн саналаар зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хороо хэлэлцэх асуудлынхаа 2 дахь хэсэг рүү орно.

Хаана байна? Ингээд санал хураалтын дүнг нийтдээ 7 гишүүн дэмжиж, 4 гишүүн татгалзаж, 63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явж дууслаа.

Төсвийн төслийнхөө хоёр дахь хэлэлцүүлгийг талаар явуулсан Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн танилцуулаагүй гишүүдээсээ 1 гишүүн санал болгон Энхтуяа гишүүн танилцуулья. Төсвийн байнгын хороонд хэлэлцүүлнэ. Юу гэнэ ээ? Энхтуяа гишүүн танилцуулах юм байна. Баярлалаа.

Монгол Улсын төсвийн 25 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хороо хоёр дахь асуултдаа асуудалдаа оръё. Өнөөдөр төлөвлөсөн ёсоор.

Хоёрдугаар асуудал маань Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын анхны хэлэлцүүлгийг.

Айн? Хураана. Ингээд хамт өргөн мэдүүлсэн 1 хуулийн нэмэлт, өөрчлөлт, Улсын Их Хурлын 2 тогтоолын асуудлыг хэлэлцэж эхэльье.

Ингээд энэ асуудалтай холбогдуулан танилцуулах ажлын хэсэг ямар хүмүүс байна?

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат дарга, Сангийн яамны газрын дарга Санжаадорж, өшөө ямар хүн байгаа юм? Ганболд байна уу хэн байна? Ажлын хэсгийн улсууд байна гэж үзлээ.

Энэ хууль санаачлагчдын зүгээс өөрөөр хэлбэл, Засгийн газраас эдгээр асуудлаар тодруулга, тайлбар хийх үү?

Тодруулга, тайлбар хийгдэхгүй юм байна.

Тэгэхээр зэрэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 39.10 дахь хэсэгт Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэльье.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хуульд оруулах тухай хуулийн төсөл 4 зүйлтэй байгаа. 4 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Байхгүй байна.

Энэ хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу?

Байхгүй байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Асуулт асуух гишүүн байхгүй юм байна. Асуулт асуух гишүүн байхгүй.

Хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Байхгүй юм байна.

Зарчмын зөрүүтэй санал гаргах уу?

Байхгүй.

Ингээд Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Байхгүй юм байна. Байхгүй юм байна.

Санал, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу?

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байхгүй байна.

Ингээд Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл тус бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Дараагийн төслийн асуудал байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг одоо хэлэлцье.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Асуулт асуух гишүүд алга.

Энэ “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа гэж үзье.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулах юм байна.

Бичгээр болон амаар санал гараагүй тул санал хураалт явуулах шаардлагагүй гэж үзлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газар чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэж дууслаа.

Дараагийн төсөл бол “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна.

Энэ асуудалтай холбогдуулаад асуулт асуу гишүүн байна уу?

Асуулт асуух гишүүн байхгүй юм байна.

Асуулт, хариулт дууссанд тооцьё.

Санал хэлэх гишүүд байна уу?

Байхгүй юм байна. Энэ дээр одоо ингээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжсэн тухай санал хураалт явуулна. Санал хураалт.

Горимын санал Баасанжаргал гишүүний төхөөрөмж нь ажиллаагүй тул санал хураалт дахиж явуулна. Санал хураалт явуулахын өмнө саяын санал хураалтыг хүчингүй болгох асуудлаар санал дахин санал хураая.

Одоо санал хураалт “Засгийн газар чиглэл өгөх тухай” Их Хурлын тогтоолыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Сая, Баасанжаргал гишүүний саналыг дэмжсэн тухай протоколд тэмдэглээд 54.5 хувийн саналаар тогтоолын төслийг дэмжлээ.

Одоо дараагийн асуудал дээр санал хураана тийм ээ. Энэ “Монгол Улсын 25 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Сая гишүүдийн асуулт, хариулт саналын тухай авчихсан.

Ингээд “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

Энхтуяа гишүүний төхөөрөмж ажиллаагүй протоколд оруулчихъя. Түрүүчийн нэгэн адил тэгээд 54.5 хувийн саналаар “Зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг дэмжлээ.

Ингээд хэлэлцүүлэх асуудал маань амжилттай дууслаа.

Манай Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхтуяа Төсвийн байнгын хороонд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газар чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаанаа өндөрлүүлье. Гишүүдэд баярлалаа.

12.33 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР